



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ  
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ  
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ


# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# 2024 3 сар










[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

[www.1212.mn](http://www.1212.mn)



## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020-2024 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

# ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2023 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
<b>Нийт мал</b>	<b>169 438</b>	<b>38 382</b>	<b>5 873</b>	<b>34 635</b>	<b>52 794</b>	<b>37 754</b>
Үүнээс:						
Тэмээ	50	26		20	2	2
Адуу	17 412	4 613	764	4 036	4 132	3 867
Үхэр	18 076	4 805	1 114	3 760	4 787	3 610
Хонь	82 410	18 380	2 487	16 917	26 988	17 638
Ямаа	51 490	10 558	1 508	9 902	16 885	12 637

## ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний III сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 III	2021 III	2022 III	2023 III	2024 III
<b>Суурин хүн ам</b>	<b>тоо</b>	<b>29 342</b>	<b>29433</b>	<b>29341</b>	<b>28926</b>	
Төрөлт	тоо	160	138	125	151	98
Нас баралт	тоо	38	26	53	29	36
Шилжиж ирсэн	тоо	611	140	176	212	194
Цэвэр өсөлт	хувь	0.42	0.38	0.24	0.42	0.21'

'суурин хүн амын урьдчилсан тооноос тооцов.

1 – 2022 оны хүн амын урьдчилсан тоо

2 - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.

## ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2023 ОН






## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2024 оны 3 сарын эцэст 64 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оны мөн үеэс 70 (2.1 дахин) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, III сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 49 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 21 (42.9%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, III сарын байдлаар



Мөн энэ хугацаанд 22 иргэн ажилд зуучлуулан орсон хувьцаат компанид 15 иргэн, улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 7 иргэн тус тус ажилд оржээ.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 9 (14.1%) нь 15-24 насны, 28 (43.8%) нь 25-34 насны залуучууд, 8 (12.5%) нь 35-44 насныхан, 18 (28.1%) нь 45-60 насныхан, 1 буюу 1.6% нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

### ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, III сарын байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2023 III	2024 III	2023 III	2024 III
<b>Ажилгүйдлийн бүгд</b>	<b>134</b>	<b>64</b>	<b>72</b>	<b>31</b>
Үүнээс:				
Дээд боловсролтой	56	23	38	17
Тусгай дунд боловсролтой	9	3	1	2
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	22	8	10	1
Ерөнхий боловсролтой	46	30	23	11
Бага болон боловсролгүй	1	-	-	-

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 23 (35.9%) нь дээд боловсролтой, 3 (4.7%) нь тусгай дунд боловсролтой, 8 (12.5%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 30 (46.9%) нь ерөнхий боловсролтой ажээ. Ажил хайгч иргэдийн 31 (48.4%) нь эмэгтэйчүүд байна.




### НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 11.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.3 (63.8%) тэрбум төгрөгөөр, зарлага 13.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.1 (32.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 8.7 (79.4%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 920.6 (8.4%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 1.1 (10.5%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 188.7 (1.7%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



## ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний III сард

Үзүүлэлт	2023	2024	Өсөлт бууралт	
	I-III	I-III	тоо	хувь
	сая төгрөг			
<b>Сангийн орлого, бүгд</b>	<b>6 687.3</b>	<b>10 953.6</b>	<b>4 266.3</b>	<b>63.8</b>
тэтгэврийн сан	5 319.7	8 695.0	3 375.3	63.4
тэтгэмжийн сан	562.1	920.6	358.5	63.8
ажилгүйдлийн сан	112.9	188.7	75.8	67.1
ҮОМШӨ <sup>1</sup> -ний сан	692.6	1 149.3	456.7	65.9
<b>Сангийн зарлага, бүгд</b>	<b>9 812.6</b>	<b>12 958.5</b>	<b>3 145.9</b>	<b>32.1</b>
тэтгэврийн сан	8 659.8	11 771.5	3 111.7	35.9
тэтгэмжийн сан	507.8	345.9	-161.9	-31.9
ҮОМШӨ-ний сан	454.5	604.7	150.2	33.0
Ажилгүйдлийн сан	190.5	236.4	45.9	24.1

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 5423 хүнд 11.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 63 хүнд 345.9 сая төгрөгийн тэтгэмж, 178 хүнд 604.7 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 63 хүнд 236.4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



### НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

<sup>1</sup> Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний III сард

Үзүүлэлт	2023		2024		2024.III	2024.I-III
	III	I-III	III	I-III	2023.III	2023.I-III
	сая төгрөг				хувь	
<b>Сангийн зарлага</b>	<b>341.5</b>	<b>4 123.6</b>	<b>1 472.5</b>	<b>4 736.1</b>	<b>431.2</b>	<b>114.9</b>
Тэтгэвэр	128.7	382.8	147.4	439.2	114.5	114.7
Тэтгэмж	36.5	105.5	97.0	295.3	265.8	279.9
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	41.3	100.5	44.3	113.0	107.3	112.4
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	1.2	113.0	-	109.4	0.0	96.8
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	0.6	163.6	0.1	171.2	16.7	104.6
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	7.5	24.5	6.4	18.0	85.3	73.5
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	14.9	2 824.7	1 060.7	3 182.3	71.2*	112.7
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	51.5	158.9	51.4	153.0	99.8	96.3
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	7.1	27.2	5.8	27.6	81.7	101.5
ХБИргэнд үзүүлсэн Хөнгөлөлт	3.4	6.6	0.9	3.4	26.5	51.5
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	13.4	40.4	12.9	38.5	96.3	95.3
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	32.6	33.2	43.2	43.4	132.5	130.7
Ихэр хүүхдийн тэтгэмж	2.0	8.0	2.0	4.0	100.0	50.0
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	3.6	-	-	-	-
Насны хишиг	0.8	131.1	0.4	137.8	50.0	105.1

\*-дахин их


Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 462 хүнд 439.2 сая төгрөгийн тэтгэвэр, 368 хүнд 295.4 сая төгрөгийн тэтгэмж, 283 хүнд 113.0 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 164 жирэмсэн эхэд 18.0 сая төгрөгийн тэтгэмж, 10.6 мянган хүүхдэд 3.2 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асардаг 1052 эцэг, эхэд 153.1 сая төгрөгийн тэтгэмж, 1719 ахмад настанд 27.6 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1070 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 38.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 41 иргэдэд 3.4 сая төгрөгийн хөнгөлөлт, 1712 хүнд 137.8 сая төгрөгийн насны хишиг, өрх толгойлсон 67 эх, эцэгт 43.4 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.



## ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний улирлын байдлаар 119 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 61 (33.9%) буурсан байна. Энэ хугацаанд 54.8 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.1 (3.8%) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 2.5 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 51 (2.0%) хүнээр тус тус буурсан байна.


ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний III сард



ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний III сард

Үзүүлэлт	2023 I-III	2024 I-III	$\frac{2024.I-III}{2023.I-III}$
Амаржсан эхийн тоо	178	120	67.4
Үүнээс бусад аймгийн харьяат	61	48	78.7
Амьд төрсөн хүүхэд	180	119	66.1
Үүнээс бусад аймгийн харьяат	60	31	51.7
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	1	2	200.0

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар





2024 оны эхний 3 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 31 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 47.7%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 (10.7%) тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 34 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 52.3%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 46 (57.5 дахин их) тохиолдлоор буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 22.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.8 продицимиллээр буурсан байна.

#### ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний III сард

Үзүүлэлт	2023 I-III	2024 I-III	Өсөлт бууралт
<b>Нийт халдварт өвчин</b>	<b>108</b>	<b>65</b>	<b>-43</b>
<b>Бэлгийн замын халдварт өвчин</b>	<b>28</b>	<b>31</b>	<b>3</b>
Заг хүйтэн	16	16	-
Тэмбүү	10	10	-
Трихомониаз	2	2	-
Кандилом	-	1	1
хомхой	-	1	1
хламид	-	1	1
<b>Цочмог халдварт өвчин</b>	<b>80</b>	<b>34</b>	<b>-46</b>
Цусан суулга	3	6	3
Салхин цэцэг	65	19	-46
Сальмонеллез	1	-	-1
Рож	1	2	1
Гар хөл амны өвчин	4	-	-4
Сүрьеэ	6	7	1



#### ГЭМТ ХЭРЭГ

2024 оны эхний 3 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 79 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 26 (49.1%) хэргээр, гэмт хэргийн илрүүлэлт 47.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.4 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

#### ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, оны эхний III сард

Хэргийн төрөл	2023 I-III	2024 I-III	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд</b>	<b>53</b>	<b>79</b>	<b>26</b>	<b>49.1</b>	<b>100.0</b>
Хүнийг алах	1	2	1	100.0	2.5
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	19	33	14	73.7	41.8
Хүчиндэх	-	1	1	-	1.3
Бусдын эд хөрөнгө хулгайлах	5	10	5	100.0	12.7
Мал хулгайлах	1	-	-1	-100.0	0.0


Залилан мэхлэх	18	14	-4	-22.2	17.7
Дээрэмдэх	1	-	-1	-100.0	0.0
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	1	10	9	900.0	12.7
Мөнгөн тэмдэгт үнэт цаас төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	-	4	4	-	5.1
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	2	-	-2	-100.0	-
Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших	1	-	-1	-100.0	-
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	-	3	3	-	3.8
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	-	1	1	-	1.3
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1	-	-1	-100.0	-
Хуурамч бичиг баримт үйлдэх, ашиглах	2	-	-2	-100.0	-
Хууль бусаар ан агнах	1	-	-1	-100.0	-
Мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	-	1	1	-	1.3
<b>Хэрэг илрүүлэлтийн хувь</b>	<b>43.8</b>	<b>47.2</b>			

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнхийг буюу 33 (41.8%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 14 (17.7%) нь залилан мэхлэх, 10 (12.7%) нь хулгайлах, 10 (12.7%) нь хөрөнгө завших хэргүүд эзэлж байна. Тайлант хугацаанд мөнгөн тэмдэгт үнэт цаас төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах хэрэг 4 (5.1%), тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 3 (3.8%), хүчиндэх, автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг, мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд тус бүр 1 (3.9%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, оны эхний III сард

Хэргийн төрөл	2023 I-III	2024 I-III	Дүнд эзлэх хувь
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд</b>	<b>53</b>	<b>79</b>	<b>100.0</b>
Гэр, орон сууцанд	16	34	43.0
Гудамж талбайд	5	12	15.2
Олон нийтийн газарт	6	6	7.6
Аж ахуйн нэгж, байгууллагад	9	16	20.3
Автозамд	-	3	3.8
Бусад	17	8	10.1

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 34 (43.0%) нь гэр, орон сууцанд, 12 (15.2%) гудамж талбайд, 6 (7.6%) нь олон нийтийн газарт, 16 (20.3%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, үлдсэн хэсэг нь буюу 11 нь (13.9%) автозам болон бусад газарт тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний III сард




ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний 3 сард



ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, оны эхний III сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2023 I-III	2024 I-III	тоо	Хувь
<b>Гэмт хэрэгт холбогдсон хүн</b>	<b>28</b>	<b>45</b>	<b>17</b>	<b>60.7</b>
Үүнээс: эмэгтэйчүүд	4	9	5	125.0
хүүхэд	-	1	1	-
<b>Гэмт хэргийн улмаас хохирсон хүн</b>	<b>50</b>	<b>76</b>	<b>26</b>	<b>52.0</b>
Үүнээс: нас барсан	1	1	0	0.0
гэмтсэн	19	36	17	89.5
Эрүүлжигдсэн хүний тоо	52	37	-15	-28.8
Баривчлагдсан хүний тоо	33	33	0	0.0
Учирсан хохирол /сая төгрөг/	109.8	101.6	-8.2	-7.5
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	32.5	21.8	-10.7	-32.9

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний III сард



2024 оны эхний 3 сард 45 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 9 (20.0%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд 76 иргэн гэмт хэргийн улмаас хохирсны 36 нь гэмтсэн иргэд бөгөөд нас барсан иргэн 1 бүртгэгдсэн байна. Мөн 37 иргэн эрүүлжигдэж, 33 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн иргэд 15 (28.8%-аар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 101.6 сая төгрөгийн хохирол учирсны 21.8 (21.5%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




## ҮНЭ ХАНШ

2024 оны 3 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


### ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, III сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих нэгж	3.01	3.08	3.15	3.22	3.29
"Алтан гурил" тариа	Дээд	кг	3 200	3 200	3 200	3 200	3 200
	I зэрэг	кг	3 000	3 000	3 000	3 000	3 000
	II зэрэг	кг	2 100	2 100	2 100	2 100	2 100
Будаа	цагаан	кг	3 800	3 600	3 700	3 600	3 600
	шар	кг	3 300	3 300	3 300	3 400	3 400
Хонины мах	ястай	кг	11 000	11 000	11 500	11 500	11 500
	цул	кг	13 000	13 000	13 500	13 500	13 500
Үхрийн мах	ястай	кг	14 000	14 500	15 000	15 000	15 000
	цул	кг	16 000	16 500	17 000	17 000	17 000
Адууны мах, ястай		кг	9 300	9 300	9 500	9 500	9 500
Ямааны мах		кг	6 500	6 800	6 800	6 800	6 800
Элсэн чихэр		кг	4 800	4 500	4 500	4 500	4 500
Сүү /задгай/		л	4 000	4 000	4 000	4 000	4 000
Тараг /задгай/		л	4 500	4 500	4 500	4 500	4 500
Цэцгийн тос, Орос		кг	6 050	6 050	6 050	6 050	6 050
Байцаа		кг	1 950	1 950	1 950	1 950	1 950
Манжин		кг	2 000	2 000	2 050	2 050	2 050
Төмс	монгол	кг	1 500	1 600	1 600	1 600	1 600
Лууван	монгол	кг	2 300	2 300	2 300	2 300	2 300
Сонгино	хятад	кг	3 000	3 000	3 000	3 000	3 000
	монгол	кг	3 000	3 000	3 000	3 000	3 000
Сармис, булцуу		ш	830	830	850	850	850
Огурцы, хятад		кг	12 000	12 000	12 250	12 250	12 250
Помидор, хятад /үрлэн/		кг	8 800	8 800	8 750	8 750	8 750
Ургамлын тос/ siesta/		ш	12 800	12 800	12 800	12 800	12 800
Өндөг		ш	700	700	700	700	700
Атар талх		ш	2 500	2 500	2 500	2 500	2 500

ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард



ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард



ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	110.5
• Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	130.3
2 тарифт тоолууртай		
• Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	116.4
• Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	89.2
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/квт.ц	164.0
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас их хэрэглээг	төг/квт.ц	187.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	164.0

• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	256.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	105.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	187.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	291.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	121.0

\* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй айл өрхөд борлуулах тариф

\*2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж буй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад борлуулах тариф

### ХҮСНЭГТ 13. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)	
Дулаан	1м <sup>2</sup>	845	1м <sup>3</sup>	1487	
Дулааны суурь тариф	40м <sup>2</sup> хүртэл	4 224	-	-	
	41м <sup>2</sup> - 80м <sup>2</sup>	7 040			
	81м <sup>2</sup> -аас дээш	14 080			
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	1 гкал	84 272	
		1м <sup>3</sup> (тоолууртай)			1 632
	Зун	1 хүн (тоолуургүй)			4 428
		1м <sup>3</sup> (тоолууртай)			1 632
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0	
	1 л (тоолууртай)	1.5			
	Ус түгээх байраар	2.72			1 л (зөөврөөр)
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0	
	1 л (тоолууртай)	1.5			
	Ус соруулах	15.0			

\* 2023 оны 7 сарын 20-ны өдрөөс мөрдөж буй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад цэвэр, бохир усны борлуулах тариф

\* 2023 оны 9 сарын 15-ны өдрөөс мөрдөж буй дулаан эрчим хүчний тариф

### ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

	2020 III	2021 III	2022 III	2023 III	2024 III
	төгрөг				
Адууны шир	9 000	7 000	9 000	5 500	-
Үхрийн шир /2.3 метрээс доош/	7 000	3 000	6 000	2 000	2 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	12 000	3 000	6 000	4 000	4 000
Хонины арьс	1 500	1 000	-	2 000	2 000
Ямааны арьс	27 000	20 000	35 000	35 000	25 000
Ямааны ноолуур	55 000	150 000	145 000	120 000	120 000

## ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2020 III	2021 III	2022 III	2023 III	2024 III
	төгрөг				
АИ -76,80	1 780	1 450	2 400	2 420	2 420
АИ -92	1 815	1 470	2 440	2 440	2 440
Дизель түлш	2 490	2 180	3 140	3 800	3 990

2024 оны 3 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-80 бензин болон АИ-92 бензин өмнөх онтой ижил түвшинд, дизель түлш 190 (5.0%) төгрөгөөр өссөн байна.




## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2024 оны эхний 3 сард 69.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.8 (5.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, эхний III сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2023 I-III	2024 I-III	<u>2024.I-III</u> 2023.I-III	2023 I-III	2024 I-III	<u>2024.I-III</u> 2023.I-III
<b>Бүгд</b>					<b>66 006.2</b>	<b>69 827.1</b>	<b>105.8</b>
Нүүрс олборлолт	м.тн	1438.0	1 498.0	104.2	62 279.8	64 878.4	104.2
Дулаан дамжуулалт	м.гкал	72.4	76.2	105.2	3 244.9	4 379.9	135.0
Талх, нарийн боов	тн	53.1	60.5	113.9	248.9	289.2	116.2
Зайлуулсан хог хаягдал	м.м3	13.0	14.5	111.5	232.6	279.6	120.2

## ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар




Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 60.0 (4.2%) мянган тонноор буюу 2.6 (4.2%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 3.8 (5.2%) мянган гкал-аар буюу 1.1 (35.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Талх нарийн боовны үйлдвэрлэлт өнгөрсөн оноос 7.4




(13.9%) тонноор буюу 40.3 (16.2%) сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 14.5 мянган метр куб хог зайлуулсан нь өмнөх оноос 1.5 (11.5%) мянган метр куб-ээр өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн эхний III сард



## НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


байна.

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1127.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 275.3 (32.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 305.5 (27.1%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний III сард

Үзүүлэлт	2023 I-III	2024 I-III	Өсөлт бууралт
	сая төгрөг		
<b>Нийт орлого</b>	<b>851.8</b>	<b>1 127.1</b>	<b>275.3</b>
Орон сууц	242.5	387.2	144.7
Ус борлуулалт, бүгд	315.0	376.0	61
Хүн амд	130.3	150.4	20.1
Аж ахуйн нэгжид	184.7	225.6	40.9
Сувагжуулалт	260.2	341.0	80.8
Бусад	34.0	22.9	-11.1

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний III сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
<b>Нийт дүн</b>	203 428.2	154 997.1	76.2
Тавлаг өргөө	42 763.5	37 535.1	87.8
Маргад өргөө	36 802.4	24 289.6	66.0
Сод хөгжил	39 177.9	32 264.6	82.4
Шинэ элч	40 655.8	31 961.4	78.6
Уурхайчин	20 700.0	17 100.0	82.6
Содон суварга	23 328.6	11 846.4	50.8

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 4 дугаар сарын 12

**WWW.1212.MN** СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
ТОГЛОМ 

Валютын ханш 



©2017


аппликейшнаас

**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ**

**Data lab** | тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**

 [www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)

 [www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)